

# УВС АЙМГИЙН ХӨТӨЧ НОМ



# УВС

## АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА МЭДЭЭЛЭЛ

1686 онд Ойрад Монголын их хаан Галдан бошигт Хархираа голоос суваг татуулж, Увс нуурын хотгор Гурван тээл, Арсай, Мянган бэл, Хар толгой, Бор үзүүр зэрэг газруудад тариа тариалж эхэлсэн нь суурин амьдралын үндэс тавигдаж улмаар Улаангом сум (хотын) анхны шав тавигдсан гэж үздэг.

Аймгийн төв: Улаангом хот

Хэдэн сумтай: 19

Нутаг дэвсгэрийн хэмжээ: 69585 км<sup>2</sup>

Хүн ам: 82,9 мянган хүн/2019 он/

Угсаатан: Монгол үндэстэн, Дөрвөд, Баяд, Халх, Элжигэн, Сартуул, Мянгад, Өөлд, Захчин, Буриад, Түрэг угсаатан, Хотон, Хасагууд

Малын тоо толгой: 3,409.25

Утасны код: +976 (0)145

Шуудангийн дугаар: 85000

ТХ-ийн улсын дугаар: УВ

Цахим хуудас: <http://www.uvs.gov.mn/>

1871 онд Чандмань уулын орчимд Дэчинравжаалан хөндийн анхны дацан болох Лүүжин дацан байгуулагдсан нь Улаангомьн хүрээний анхны суурь болсон байна. Лүүжин Дацангийн дэргэд Цогчин дуган, олон сүм баригдаж, лам хуврагууд олноор шавилан сууснаар Баянчандмань уулын хошуу байгуулагдаж, хошууны тамгын газар төвлөрснөөр Улаангомьн хүрээ нэртэй болсон байна. Улаангомьн хүрээ нь сүсэгтэн олны дунд ихээхэн нөлөөтэй болж 1915 оны үед 1500 гаруй лам хуврагтай болж, Дөрвөдийн Зоригт Далай хааны өргөө байрлаж байсан зэрэг нь хошууны шашин, улс төр, засаг захиргааны төв болж өргөжихөд нөлөөлсөн байна. 1931 оны 2 сард Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор засаг захиргааны хуваарийг шинэчлэн Чандмань уулын аймгийг Увс, Ховд хоёр аймаг болгосноор Улаангом нь 12 багтайгаар Увс аймгийн улс төр, эдийн засаг, соёл боловсролын төв болон өргөжин хөгжих эхлэлээ тавьсан юм.



# УЛААНГОМ

ХОТЫН ТУХАЙ



1931 оны 2 сард Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор засаг захиргааны хуваарийг шинэчлэн Чандмань уулын аймгийг Увс, Ховд хоёр аймаг болгосноор Улаангом нь 12 багтайгаар Увс аймгийн улс төр, эдийн засаг, соёл боловсролын төв болон өргөжин хөгжих эхлэлээ тавьсан юм.

Өрхийн тоо: 8578 /2019он/

Хүн амын тоо: 30217/2019он/

Улаанбаатар хотоос алслагдсан зай:1336 км



**ТӨГС ЦЭНХЭР ХЯЗГААР**  
УВС АЙМАГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБОО

УВС АЙМГИЙН

# ТӨГС ЦЭНХЭР ХЯЗГААР

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБОО

Төгс цэнхэр хязгаар” Увс аймаг аялал жуулчлалын холбоо НҮТББ 2020 оны 2 сарын 2-ны 14.00 цагт Онцын тасархай ХХК-ны захирал Ж.Батсүхийн санаачлагаар УЗ-ын 11 гишүүнтэйгээр үүсгэн байгуулагдсан.

Тус холбооны зорилго нь Увс аймгийн АЖ-ын салбарын хөгжлийн бодлогыг Төрийн болон ТББ-тай хамтран гаргаж хэрэгжүүлэх, Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, төрийн ажлыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэхэд оршино.

# УВС АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МАРШРУТУУД

## 1-р маршрут

*/Байгаль, түүхийн аяллын төрөлд  
хамаарна/*

**Чиглэл нь:**

Улаангом-Тариалан - Хархираан  
Цагаан хэрц - Хархираан эхэн -  
Хархираан даваа- Олон нуур -  
Түлээ ачдаг даваа - Бага ямаат -  
Ямаатын хавцал - Тэл мод -  
Хотгорын уурхай - Байрамын  
даваа - Үүрэг нуур – Улаангом.  
Маршрутын нийт урт – 273 км.  
Хугацаа - 7 шөнө 8 өдөр

## 2-р маршрут

*/Байгаль, түүхийн аяллын төрөлд  
хамаарна/*

**Чиглэл нь:**

Улаангом-Тариалан - Хархираан  
Цагаан хэрц - Хархираан эхэн -  
Хархираан даваа- Олон нуур -  
Дамжиг – Гоожуурын хүрхрээ –  
Шаазгай нуур – Улаангом. Аяллын  
замын нийт урт- – 314 км.  
Хугацаа-6 шөнө 7 өдөр.

## 3-р маршрут

*/Байгаль, түүх соёл,  
палентлогийн аяллын төрөл/*

**Чиглэл нь:**

Улаангом-Зүүнговь – Баян нуурын  
хоолой – Урт булаг - Нарийний эх  
– Дөрөө нуур - Тохой – Тэс сум –  
Тэсийн гол – Нарийний адаг – Увс  
нуур – Улаангом. Аяллын нийт  
урт - 622 км. Хугацаа- 6 шөнө 7  
өдөр.

## 4-р маршрут

*/Загасчлах аялал/*

**Чиглэл нь:**

Аялалын зам:  
Б о р ш о о - У л а а н г о м - Х а р  
тэрмис-Улаангом- Боршоо боомт  
Нийт аяллын замын урт – 402км.  
Хугацаа- 2 шөнө 2 өдөр  
Загасчлах аяллын хугацаа: 06  
сарын 1-ээс -09 сарын 1-ны  
хооронд ирэх боломжтой

# ҮЗМЭРҮҮД

## УВС АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### УВС НУУР

Увс нуурын Дархан цаазат газар нь Улаангом хотоос 36 км-т оршино. Увс нуур нь Монголын хамгийн том нуур нийт 3350 га талбайтай, уртаараа 84 км, өргөнөөрөө 79 км. Гүн нь 12-15 м, зарим газраа 29 м хүрнэ. Эргийг нь дагаж тойрвоос 450 км урт. Ай савын хамгийн нам цэг далайн төвшнөөс дээш 758.9 м, хамгийн өндөр цэг далайн төвшнөөс дээш 4126 м өргөгдсөн Хархираа, Түргэний ноён оргил юм. Нас нь 200 сая жил гэж эрдэмтэд тогтоожээ. Увс нуурт Тэс, Нарийн, Хархираа, Түргэн, Хөндлөн, Сагиль, Боршоо, Хандгайт, Торхлиг зэрэг их бага 38 гол цутгана. Увс нуур, түүний цутгал голуудын ай сав, дагуу хар мод, хуш, улиас, зэгс, чацаргана, чихэр өвс, үхэр манжин зэрэг олон зүйлийн ургамал ургана. Бор гөрөөс, гахай, буга нутагшсаны гадна олон төрлийн жигүүртэн шувууд, загас жараахай байдаг. 245 зүйл шувууд энэ бүс нутагт бүртгэгдсэн бөгөөд нэн ховорт тооцогдох халбаган хошуут, цасч дэглий, ямаан сүүлт, итэлгэн цахлай, ухаа шумбуур, усны цагаан сүүлт бүргэд зэрэг ус намгийн шувууд бий.



# ҮЗМЭРҮҮД

## УВС АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **ХЯРГАС НУУР**

Увс аймгийн Завхан, Наранбулаг, Цагаанхайрхан, Малчин, Хяргас сумын нутагт Их нууруудын хотгорт, Ханхөхий нурууны урд хэсэгт, Нуурын гадаргын талбай нь 1407 хавтгай дөрвөлжин километр, хамгийн урт нь 75 километр, өргөн 31 километр, дундаж өргөн нь 19 километр, усны мандал нь далайн төвшнөөс дээш 1028 метр өндөрт оршино.

Хяргас нуур нь тектоникийн хотгорт тогтсон учраас эргийн шугам хэрчилт ихтэй. Тийм учраас хэд хэдэн нарийн хошуу түрж орсон байдаг. Тэдгээрийн дотор хамгийн том нь Нуурын шугам бөгөөд 7 километр байдаг бол Чацарганы шугам нь 4 километр, Могойн шугам нь 5 километр байдаг.

Нуурын эргээс жаахан гүн рүү ороход 40-50 метр хүртэл гүнзгий болно. Хамгийн гүнзгий нь Чацарганы шугам орчимд 80 метр хүрнэ.

Алтайн нурууны зүүн ба хойд хажуу, Хангайн нурууны баруун хажууг бүхэлд нь хамарсан 170 мянган хавтгай дөрвөлжин уудам нутгаас усжина. Хяргас нуурын урд хөвөөнд таваг чулууны булаг, хойд хэсэгт Чоно долоохын булаг, Могойн булаг зэрэг булаг шандтай. Нуурын хойд эрэг дээр Хар тэрмэсийн рашаан хэмээх амралт сувиллын газар бий. Дотор өвчин анагаах рашаан байхаас гадна шаврыг нь эмчилгээнд хэрэглэдэг.



# ҮЗМЭРҮҮД

## УВС АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **АЛТАН ЭЛСНИЙ ДАРХАН ЦААЗАТ ГАЗАР**

Алтан элс нь Увс нуурын хотгорын зүүн хэсэгт орших Бөөрөг элсний зүүн хэсгийн Алтан элсийг ларна. Талбай нь 177.5 мянган га юм. Элсэн дороос эх аван урсдаг цэнгэг устай гол горхи, булаг шанд, баян бүрдүүд болон элний нүүлт зэрэг яын нөлөөнд автагдаагүй манхан элс, эрт дээр үсийн амьтдын үлдэгдэл, түүхийн дурсгалыг Хадгалан үлдэх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авчээ.

Алтан элсний гарал үүсэл нь нэг талаас нуур-пролювийн гаралтай дөрөвдөгч галавын хурдас, баруун хойт зүгээс байнга үлээх салхиар хийсэн хуримтлагдсантай, нөгөө талаас суурь чулуулгийн өгөршилтэй холбоотой. Энд сөөгөнцөр, дэгнүүлт үстэн, алаг өвс бүхий элсний бүлгэмдэл голлоно.

Уг бүлгэмдэлд хиаг, срхөг, агь, ганга, цагаан бургас зэрэг ургамал ордог. Элсний урд хаяа дагуу хэсэг, хэсэг нарс, шинэс, чацаргана ургана. Амьтдаас суусар, туулай, тарвага, мануул, атигдаахай байхаас гадна улирлын байдлаас хамаарч усны шувууд ирж зусна. Алтан элс нь дов толгодлог гадаргатай ба түүнийг элсний зүүн хэсэгт элсэн дунд орших Эрдэнэтолгой, Залаа толгой, Хөх толгой зэрэг нам уулс гэрчилнэ. Алтан элсний кластерт элсэн манхнаас гадна түүнд бэхлэгдэн ургасан бага хэмжээний нарс, шинэс, чацаргана нь маш их юм.





# ҮЗМЭРҮҮД

## УВС АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **ХАНХӨХИЙ УУЛС**

Нийслэл Улаанбаатар хотоос 1160 км, Аймгийн төв Улаангомоос 270км зайд алслагдсан.

Ханхөхий нурууг 2205 ам километр талбайгаар, Хяргас нуур орчмыг 3320 ам километр талбайгаар 2000 онд улсын тусгай хамгаалалтанд авчээ. Ханхөхийн нуруу нь цөлийн хээрийн бүс нэмэгдэх үйл явцыг хязгаарладаг экологийн тэнцвэрийг хадгалахад чухал ач холбогдолтой газар юм. Хангайн нурууны баруун хойд залгаа болж оршино. Оргил нь Дуулга уул бөгөөд далайн төвшнөөс дээш 2928 метр өндөр.

Ханхөхий уул нь ой мод, ус, гол элбэгтэй томоохон уул бөгөөд Увс аймгийн Зүүнхангай, Өвөрхангай, Цагаанхайрхан сумын нутагт оршдог. Ханхөхийн нуруу нь их нууруудын хотгорлуу түрж орон Увс болон Хяргас нууруудын хотгорыг зааглана. Алмаз эрдэнээс эхлээд олон төрлийн эрдэнэс бий. Эрт дээр үеэс ургамал амьтнаар баялаг гэдгээрээ алдаршжээ. ҮІ-ҮІІІ зууны үед Түрэг үндэстнүүд Монгол газар нутаглаж байхдаа Отгонтэнгэр уулаас гадна Ханхөхий уулыг тахин шүтэж байсан тухай баримт байдаг.

Ардын эмнэлэг болон эмийн үйлдвэрийн үнэт түүхий эд болсон Алтан гагнуур, алтан хундага, юмдүүжин, чацсэржим, рэ гомбо, тэхийн шээг, төлөгч өвс, шархны шар, манчин, хөх шар дэгд, ганга, мэхээр, таван салаа зэрэг эмийн ургамлууд аньс, нохойн хошуу, үхрийн нүд, самар зэрэг анагаах чадвартай амт тансаг жимс жимсгэнэ элбэг ургадаг.



*Nyamdorj D*

# ҮЗМЭРҮҮД

## УВС АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **ЧАНДМАНЬ УУЛЫН ДУРСГАЛ**

Улаангомьн сав газар бол эртний их түүхтэй, соёл иргэншлийн өлгий болсон нутаг юм. Хархираагийн нуруунаас буусан олон голуудын үржил шимт хөндий. Улаангомьн сав нутаг нь нэн эртнээс хүн оршин амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлсэн бүс нутаг байж түүхийн олон үеийн дурсгалыг өөртөө агуулсаар иржээ. Монгол алтайн нуруу, их нууруудын хотгор нь эртний хүмүүсийн өлгий нутгийн нэг байсан нь Монгол төдийгүй дэлхийн хэмжээнд яригдах цөөн хэдэн дурсгалууд эндээс олдсонтой холбоотой. Тэр дундаа Улаангомьн хэмээн тодотгогдох Чандманий соёл бол Монгол, Төв ази төдийгүй дэлхий дахины хэмжээнд яригдах бие даасан цогцолбор соёлын нэгэн мөнөөс мөн ажээ.

Эл дурсгал нь хүрэл, төмрийн түрүү үеийн хоёр томоохон иргэншил болох дорнод монголын дөрвөлжин булш, дундад азийн скифийн соёл иргэншилийн холбоосон дээр оршиж тэр утгаараа энэ хоёр соёл иргэншлийн агуулгыг аль алины нь онцлогийг өөртөө агуулсан ихээхэн өвөрмөц онцлог бүхий дурсгал. Монголын төмөр зэвсгийн түрүү үе буюу мээ VII-III зууны үед холбогдох иж бурэн дурсгал бол Увс аймгийн Улаангом хотын дэргэдэх Чандмань ууланд буй цогцолбор соёл юм. Анх 1972 онд Улаангом хотноо газар шорооны ажил хийж байсан хүмүүс барилгын шороо хайрга Чандмань уулын бэлээс авах үед дүнзэн хашлагатай булш ил гарч, ийм булш байгааг олж мэдсэн ажээ.



# ҮЗМЭРҮҮД

## УВС АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### ГООЖУУРЫН ХҮРХРЭЭ

Ховд сумын нутагт Хархираа, Түргэний уулсын баруун урд оршино. Байгалийн үзэсгэлэнт газар. Гоожуурын хүрхрээ 17м өндрөөс унана. Олон нуурын уулс нь д.т.д 3000м өндөр. Мөнх цас, сүрлэг хад уулс, улаан номд орсон нэн ховор ирвэс, аргаль, янгир, буга зэрэг 20 зүйлийн ан амьтан, 30 гаруй зүйлийн ургамалтай. Том жижиг 108 нууртай. Шар, ногоон, сүүн цагаан зэрэг олон өнгөтэй. Мөн Вансэмбэрүү цэцэг харах боломжтой.



# ҮЗМЭРҮҮД

## УВС АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### ДЭГЛИЙН ЦАГААН УУЛ

Монгол Алтайн нурууны цавчим хаднуудаас үүсэлтэй Түргэний уулсын ноён оргил Цагаан дэглий уул нь далайн төвшнөөс дээш 4096 метр өндөр. Түргэний уулс нь Бөхмөрөн, Сагил сумыг дамжин 70 орчим километр үргэлжлэх уулс бөгөөд Цагаан дэглий уулаас зүүн тийш Хавцалын боом хүртэлх 145.1 мянган га талбайг хамарна.

Цагаан дэглий уул нь ой тайгатай, уулын түргэн урсгалт гол горхиудтай, мөнх цастай, мөсөн голтой, бэлээрээ үзэсгэлэнт нууруудтай, өвөрмөц тогтоц бүхий хадан хясаатай, ховор болон ховордсон ургамал амьтны аймагтай. Энэ уулнаас Түргэн, Буурал, Хархираа, Ямаатын голууд эх авна. Түрэгийн үеийн болон өмнөх үеийн хүн чулуун хөшөөнүүд, хадны сүг зураг, хиргисүүр, булш бунхан, Төгс буянт хийдийн туурь зэрэг түүх соёлын дурсгалуудтай. Сүүлийн жилүүдэд мөсөн гол нь хайлж татарч байгаа ажээ..



# БУСАД ҮЗМЭРҮҮД



## МӨНГӨТ ЦАХИР УУЛ

Давст сумын төвөөс 50 орчим км-т цагаан саарал өнгийн шохойн гантиг чулуунаас тогтсон мөнгөлөг цагаан өнгөтэй д.т.д 1600 метр өндөрт орших уулыг Мөнгөт цахир уул гэдэг. Монгол улсын дархан цаазат энэ уулын аманд байрлах зурагт буга, янгир ямаа, олон тооны тамга тэмдэг, хүний нүүрийг дүрсэлсэн байдаг.

Уулын зүүн талын аманд хадны дээд хэсэгт эгц урдаас нь харсан хүний нүүрийг дугуйд багтаан хөмсөг, нүд, хамар амтай дүрсэлжээ. Түүний доор цаашаа хараад зогсож буй шовгор оройтой малгай өмссөн хүний их биеийн хэсгийг хөвөөлөн гаргасан эдгээр дурсгалыг МЭӨ 3-1 мянган жилд холбогдоно гэж судлаачид үздэг.

## ЗУРААГИЙН ХАДНЫ ЗУРАГ

Увс аймгийн Зүүнхангай сумын төвөөс хойш 14 километр орших Зураагийн хошууны өвөр талын таван том улаан хадыг "Зураагийн улаан хад" хэмээнэ. Дунд талын хоёр хаданд эртний хүмүүсийн улаан зосоор зурсан зургууд бий. Эдгээр хаданд нисэж яваа шувуу мэт дүрс, зөв буруу солбисон дэгрээ тэмдэгнүүд, хавирган сар мэт дүрс, дундаа цэгтэй гурвалжин дүрс, Х үсэг мэт дүрс, олон тооны цэг зураас, дугуй цагираг босоо зурааснууд, янгирын

толгой бүхий урт иштэй эдлэл, амьтны арьс дэлгэсэн мэт дүрс, алцайж зогссон хүний дүрс, хоёр гараа унжуулан зогссон хүн, цээж их биеийг гурвалжин дүрсээр гаргасан зэрэгцээ хоёр хүн, хоёр гараа дэлгэж нэг гартаа юм барьсан хүн, салаа оройтой малгай өмсөөд бүжиглэж байгаа мэт хоёр хүн, хөлөө өвдгөөр нь нугалан дутуу явган сууж хоёр гараа дэлгээд нэг гартаа ямар нэгэн юм барьсан хүн зэрэг дүрслэлүүд байдаг. Эдгээр нь шинэ чулуун зэвсгийн үед холбогдох дурсгал хэмээн тодорхойлжээ.

## ХАРХИРАА, ТҮРГЭНИЙ УУЛС

Увс нуур, Ачит нуурын хооронд улсын хилээс дотогш Ховд гол хүртэл үргэлжилдэг уулархаг нутгийг Хархираа, Түргэний уулс хэмээн нэрлэдэг.

Алтайн нурууны салбар уулс Хархираа, Түргэний уулс нь олон сүрлэг сайхан оргилуудтай ихэр уулс юм. Хархираагийн уулсын ноён оргил нь Мөст уул 4037 метр /далайн төвшнөөс дээш/, Түргэний уулсын ноён оргил нь Дэглий Цагаан уул 3965 метр /далайн төвшнөөс дээш/ юм.

Хархираа Түргэний уулс нь Хархираагийн даваа гэсэн хөтлөөр хоорондоо тусгаарлагддаг байна.

# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУД

## ХЯРГАС НУУР ОРЧМЫН БААЗУУД



### ХЭЦҮҮ ХАД

Увс аймгийн  
Завхан сум

99067339, 98827339

facebook.com/khetsuukhadcamp/  
lounge.resistors.showroom

46.2729° N, 102.7790° E




### ХЯРГАС НУУР РЕСОРТ

Увс аймгийн  
Завхан сум

99993990

facebook.com/khyargasnuuresort/  
lounge.resistors.showroom

46.2729° N, 102.7790° E



### BARUUN BEACH

Увс аймгийн  
Завхан сум

99001903  
89459911


facebook.com/baruunbeachcamp/

lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E

# ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУД



## УЛААНГОМ ХОТЫН ЗООГИЙН ГАЗРУУД



### ХАН-ХӨХИЙ

Увс аймгийн  
Улаангом хот

90452222

Монгол, Европ, Ази хоол  
[www.facebook.com/hanhuhiiUvs/](http://www.facebook.com/hanhuhiiUvs/)

lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



### ГРАНД

Увс аймгийн  
Улаангом хот

99454435

Монгол, Европ хоол  
[www.facebook.com/grandhotelrestaurant/](http://www.facebook.com/grandhotelrestaurant/)

lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



### САРНАЙ

Увс аймгийн  
Улаангом хот

99452111

Пицца хүргэлт  
[www.facebook.com/Sarnai.restaurant/](http://www.facebook.com/Sarnai.restaurant/)

lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E

# ЭВЭНТ БАЯР НААДМУУД

## ОЙРАД ТҮМНИЙ ЯЗГУУР ОУ-ЫН НААДАМ”

АЗДТГ, СЗДТГ, Онцын тасархай ХХК, Ойрад түмэн ТББ, БОАЖГ хамтран зохион байгуулдаг. Тус Монгол улсын болон ОХУ-ын Халимаг, Тува, Горны Алтай, БНХАУ-ын Шинжаан Уйгарын ӨЗО, Өвөр монгол, Дээд Монголчуудын ардын авьяастнууд, жуулчид өөрсдийн авьяас чадвараар өрсөлдөн оролцдог.

### **ХУГАЦАА:**

8 сарын 4-бны өдрүүдэд

### **ХААНА:**

Түргэн сум. Хиргэнэ

### **ХӨТӨЛБӨР:**

Ирсэн жуулчдад Монгол ахуй соёлыг үзүүлж сонирхуулах зорилготой нүүдэлчдийн ахуй амьдралыг харуулсан үзүүлбэр зохион байгуулахаас гадна бяцхан бэсрэг наадам зохион байгуулдаг.



## ТЭМЭЭ – МӨС – ЗАГАСЧЛАЛ

Завхан сумын ЗДТГазар, Сайхан Халиун ХХК, СЗДТГ, БОАЖГ хамтран Завхан суманд жил бүр 10000 тэмээтэй холбоотойгоор түмэн тэмээний баярыг зохион байгуулдаг.

### **ХУГАЦАА:**

Жил бүрийн 3 сарын 6,7ны өдрүүдэд

### **ХААНА:**

Завхан сум, Хяргас нуур, Айраг нуурын хоолой

### **ХӨТӨЛБӨР:**


Хяргас нуур, айраг нуурын хоолойд мөсний баяр зохион байгуулах, Загасчлалын тэмцээн зохион байгуулна.






**МАРШРУТ-1**

Улаангом-Тариалан - Хархираан Цагаан хэрц - Хархираан эхэн - Хархираан даваа- Олон нуур - Түлээ ачдаг даваа - Бага ямаат - Ямаатын хавцал - Тэл мод - Хотгорын уурхай - Байрамын даваа - Үүрэг нуур – Улаангом.  
Маршрутын нийт урт – 273 км. Хугацаа - 7 шөнө 8 өдөр



**МАРШРУТ-2**

Улаангом-Тариалан - Хархираан Цагаан хэрц - Хархираан эхэн - Хархираан даваа- Олон нуур - Дамжиг – Гоожуурын хүрхрээ – Шаазгай нуур – Улаангом.  
Аяллын замын нийт урт- – 314 км. Хугацаа-6 шөнө 7 өдөр.



# УВС АЙМГИЙН АЯЛЛЫН МАРШРУТ